

НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗАР

Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл,
Нийслэлийн 2025 оны хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсан бодлогын зорилтуудын хэрэгжилт

2025 оны 06 дугаар сарын 02

Улаанбаатар хот

Д/д	Үндэслэж байгаа бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилт от түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Хувь
	1	2	3	4	5	6	7
1.	Нийслэлийн өмчийн байр, талбайг зах зээлийн бодит үнэлгээгээр иргэн, аж ахуйн нэгжүүдэд түрээслүүлж, төсөвт төвлөрүүлэх орлогыг нэмэгдүүлэх НХТЖҮЧ-4.1.1, НЗДҮАХ-3.1.1.2, ХАХТ-3.1.1.3	-	Нийслэлийн төсөвт төвлөрүүлэх түрээсийн орлого, сая.төг	3,136,5	3,068,9 /Жил/	НИТХТ-ын 2014 оны 65 дугаар тогтоолоор баталсан "Нийслэлийн өмчийн эд хөрөнгийг түрээслэх журам"-ын дагуу иргэд, аж ахуй нэгж, байгууллагуудтай нийслэлийн өмчийн барилга, байгууламжийн гурвалсан гэрээ 131, хоёр талт гэрээ 16, Үдийн цай хөтөлбөрийн 35, нийт 182 түрээсийн гэрээг баталгаажуулан, гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж, жил бүр дүгнэн ажиллаж байна. 2025 оны түрээсийн жилийн орлогын төлөвлөгөөг 3,068.9 сая төгрөгөөр баталж, түрээсийн орлого төвлөрүүлэх батлагдсан хуваарийн дагуу 895,0 сая төгрөг төвлөрүүлэхээс 2025 оны 05 дугаар сарын 30-ний өдрийн байдлаар 730,1 сая төгрөгийг нийслэлийн төсөвт төвлөрүүлсэн. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2020 оны 49 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн төлбөрийн доод хязгаар, түрээсийн зарим төлбөрийн хэмжээг тогтоох заавар, улсын төсөв төвлөрүүлэх орлогын хувь хэмжээг шинэчлэн батлах тухай" тогтоолд заасан түрээсийн төлбөрийн доод хязгаарын 1мкв үнэ 6000-15000 тогтоосон байна. НИТХТ-ийн 2014 оны 65 дугаар тогтоолоор баталсан " Нийслэлийн өмчийн байр, талбайг түрээслэх түрээслэгчийг сонгон шалгаруулах журам" дагуу сонгон шалгаруулалт зохион байгуулаж Нийслэлийн өмчийн байр талбайг иргэн, аж ахуй нэгжид 1мкв талбайг 25000-45000 түрээслүүлэн ажиллаж байна.	90%

ДАРГА *В. Оюумаа* В.ОЮУМАА

ХЯНАСАН: ЗУХ-ИЙН ДАРГА *Т. Оюунтуул* Т. ОЮУНТУУЛ

НЭГТГЭСЭН: ЗУХ-ИЙН МЭРГЭЖИЛТЭН *М. Энхбаяр* М.ЭНХБАЯР